



**БУЛГАН АЙМГИЙН  
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2020 оны 05 сарын 06 -ны өдөр

Дугаар А-06

Булган

Үржлийн малд үзлэг ангилалт хийх,  
цөм сүрэг бүрдүүлэх, баталгаажуулах, бүртгэлжүүлэх  
ажлыг зохион байгуулах тухай

Малын генетик нөөцийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 6 дугаар зүйлийн 6.4, 11 дүгээр зүйлийн 11.6, 11.6.3, УИХ-ын 2010 оны 23 дугаар тогтоол "Монгол мал" үндэсний хөтөлбөрийн 3.2.1, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйдвэрийн сайдын 2020 оны "Үржлийн малд үзлэг, ангилалт хийх, баталгаажуулах ажлыг төсвийн хуваарьт батлах тухай" А-112 дугаар тушаал, Аймгийн Засаг даргын 2020 оны "Ажил зохион байгуулах тухай" А/209 дугаар захирамжийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Үржлийн малд үзлэг ангилалт хийх, цөм сүрэг бүрдүүлэх, бүртгэлжүүлэх ажлын төсвийн хуваарийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
2. Үржлийн малд үзлэг ангилалт хийх, цөм сүрэг бүрдүүлж, баталгаажуулах ажлын хэсгийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
3. Үржлийн малд үзлэг, ангилалт хийх, баталгаажуулах ажлыг технологийн хугацаанд үр дүнтэй зохион байгуулж, стандартын шаардлага хангасан үржлийн малыг ялган тэмдэглэж, малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд хамруулж, явцын тайланг 06 дугаар сарын 20, нэгдсэн тайланг 11 дүгээр сарын 05-ны дотор тайлагнахыг Мал үржлийн алба /М.Жавзандолгор/-т үүрэг болгосугай.
4. Баталсан хуваарийн дагуу аж ахуй нэгжүүдэд санхүүжилтийг олгож, хяналт тавьж, шаардлагатай мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангаж ажиллахыг Ерөнхий санхүүч /Л.Отгон/-т үүрэг болгосугай.

ДАРГА Ч.АМГАЛАН

